



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

Богино хэмжээний видео танилцуулга бүтээх ажлын даалгавар

А. Төслийн танилцуулга

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь Дэлхийн банкны санхүүжилттэй “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл” (ХЭДТ)-ийг 2017-2021 оны хооронд хэрэгжүүлж байгаа бөгөөд уг төсөл нь ажил хайгчид болон бичил бизнес эрхлэгчдийн хөдөлмөрийн зах зээлийн боломжуудыг бичил зээл болон техник туслалцаагаар дамжуулан нэмэгдүүлэх зорилготой.

Төслийн хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлэх, олон нийтийг шаардлагатай мэдээллээр хангах зорилгоор ХЭДТ-ийн Төслийн удирдах хороо “Мэдээлэл сурталчилгааны ажлын төлөвлөгөө”-г баталсан. Уг төлөвлөгөөний дагуу 2019 онд төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн болон төслийн ерөнхий мэдээллийг олон нийт, төслийн үр шим хүртэгчдэд хүргэх зорилгоор богино хэмжээний видео танилцуулгуудыг 2019 оны 6 дугаар сараас 10 дугаар сар хүртэл хугацаанд бэлтгэхээр төлөвлөөд байна. Эдгээр видеог телевизийн сувгаар цацахын зэрэгцээ нийтэд зориулсан арга хэмжээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтсийн болон засаг захиргааны анхан шатны нэгжийн цахим хуудаснууд, фейсбүүкээр дамжуулан олон нийтэд хүргэнэ.

В. Ажлын агуулга, хүрээ

Сонгогдсон студи нь ХЭДТ болон бусад оролцогч талуудын тусламжтайгаар дараах сэдэв, хугацаа бүхий 6 богино хэмжээний видео танилцуулгыг бүтээнэ:

№	Сэдэв	Хэмжээ	Хугацаа
1	Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт	2 мин	2019.06
2	Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт	30 сек	2019.06
3	Бичил бизнес эрхлэгчдэд зориулсан арга хэмжээ	2 мин	2019.06
4	Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд ажил олгогчдын гүйцэтгэх үүрэг (ажил олгогчдод зориулсан)	1.5 мин	2019.06
5	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн танилцуулга	2 мин	2019.07
6	“Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ирээдүй” сэдэвт үндэсний бага хурлын танилцуулга	3 мин	2019.10

Сонгогдсон студи нь видео бүтээхдээ ХЭДТ-өөс өгсөн мэдээлэлд үндэслэн зорилтот бүлгийн үзэгчдийн сонирхлыг татахуйц видео зохиол болон хар зургийг

видео тус бүр дээр гаргана. Видеонууд нь анимэйшн, график, дүрс хосолсон хэлбэртэй байна.

С. Нийлүүлэх бүтээгдэхүүн

Студи нь уг ажлын хүрээнд дараах бүтээгдэхүүнийг хүлээлгэж өгнө.

1. HD-1080, AVI формат бүхий 6 богино видео танилцуулгыг дээр дурдсан хугацаанд хүлээлгэж өгөх;
2. Монтаж хийгдээгүй зураг авалтын эх дүрсүүд;
3. Гэрээт ажил гүйцэтгэсэн тухай эцсийн тайлан;

Д. Оюуны өмч болон нууцлал

Уг ажилд холбогдох видео, аудио, цаасан хэлбэрийн материалууд нь ХНХЯ-ны оюуны өмчид хамаарна. Студи нь видео танилцуулга бүтээхэд зориулагдсан бүхий л төрлийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр олон нийтэд хэсэгчлэн болон бүхлээр нь тараахгүй байх үүрэгтэй.

Е. Тавигдах шаардлага

- Албан ёсны гэрчилгээ бүхий хуулийн этгээд байна.
- Видео танилцуулга, киноны чиглэлээр 3-аас дээш жил ажилласан туршлагатай найруулагч/редактор, зураглаач, график дизайнер бүхий мэргэжлийн багтай байх,
- Олон нийт болон зорилтот бүлгүүдэд чиглэсэн 2-оос 4 минутын богино хэмжээний видео бүтээл хийж байсан туршлагатай,
- HD форматын мэргэжлийн тоног төхөөрөмжтэй,
- Албан ёсны байршил, хаяг, утасны дугаар, и-мэйл-тэй,
- Өргөн сэдвийн хүрээнд богино хугацаанд чанартай бүтээл хийж байсан туршлагатай.

Ф. Явцын тайлан, үр дүнг хянах

Студи нь дээр дурдсан ажлыг ХЭДТ-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хяналт дор гүйцэтгэнэ. Студийн ажлын гүйцэтгэлийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ. Үүнд:

- Ажлын даалгаварт тусгасан ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн байдал;
- Төлөвлөсөн ажлуудаа хугацаанд нь хэрэгжүүлсэн байдал;
- Гүйцэтгэсэн ажлын чанар;

Г. Гэрээний хугацаа

Уг ажлыг **2019 оны 6 дугаар сараас 10 сарыг дуустал** хугацаанд гүйцэтгэнэ.

Н. Бусад зохицуулалт

ХЭДТ-ийн зүгээс ямарваа нэгэн техник, тоног төхөөрөмж худалдан авч хангалт хийхгүй. Видео бүтээхэд шаардагдах тоног төхөөрөмжийг тухайн студи өөрөө хариуцна.

Зураг авалтын үеийн унааг студи хариуцах бөгөөд зураг авалт зөвхөн Улаанбаатар хотод хийгдэнэ.

Сонгон шалгаруулалтад орох хүсэлтэй студи нь тавигдах шаардлагыг хангаж буйг илэрхийлэх баримт бичгүүдийг уг ажлыг хариуцан гүйцэтгэхэд оролцох ажилтнуудын анкет, өмнө хийж байсан бүтээлийн мэдээлэл, тус ажлыг гүйцэтгэх үнийн саналын хамт mesp@mlsp.gov.mn цахим хаягаар болон Улаанбаатар-15170, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Макс цамхаг, 701-702 өрөөнд 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 10.00 цагаас өмнө ирүүлнэ үү.

Холбогдох утас: 7700 0784

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ